



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 20 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 20 дугаар хуралдаан 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 20 дугаар хуралдаанаар /2025-09-30/ Захиргааны хэм хэмжээний актад хийсэн үзлэгийн хүрээнд ЗХХА-д бүртгэлгүй зарим баримт бичгүүдийг хүчингүй болгох тухай (Хорооны 2014 оны 32 тоот, 2015 оны 41 тоот, 2016 оны 18 тоот тогтоол); ХХЗХ-ны Радио давтамжийн хяналт баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх хүрээнд оффисын шинэ барилга барих зураг төслийн загварын тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт;) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 6 (Тогтоол №210-215, 2025-09-30) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

ХХЗХ-ноос 2025 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар, УИХ-аас 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай зэрэг хууль, тогтоомж баталсантай холбогдуулан тус Хороонд олгосон бүрэн эрхийн хүрээнд Хорооны хуралдаанаар баталсан 38 захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан шинээр, шинэчлэн болон нэмэлт өөрчлөлт оруулан баталж, ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд хянуулан бүртгүүлэх арга хэмжээг авч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. ХЗДХЯ-наас 2025 оны 05 дугаар сард ирүүлсэн “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай” 1/2212 дугаар албан бичгийн дагуу баримт бичигт хийсэн үзлэгээр одоо хүчинтэй байгаа боловч захиргааны хэм хэмжээний актад бүртгэлгүй, байгууллагын дотоод зохион байгуулалтын шинжтэй, ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөхгүй болсон зохицуулалтын баримт бичгийг хүчингүй болгох шаардлагатай болж, энэхүү арга хэмжээг тус хорооноос үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ арга хэмжээний хүрээнд холбогдох бүтцийн газар нэгж, Хуулийн хэлтсээс хамтран Хорооны баталсан дараах 3 тогтоолыг хүчингүй болгох “Захиргааны хэм хэмжээний актад хийсэн үзлэгийн хүрээнд ЗХХА-д бүртгэлгүй зарим баримт бичгүүдийг хүчингүй болгох тухай” танилцуулга, эрх зүйн үндэслэл, санал дүгнэлт, тогтоол цуцлах төслийг боловсруулсан байна. Үүнд: Тус хорооны 2014 оны 7 сарын 4-ний өдрийн 32 тоот тогтоолоор батлагдсан “Телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог системийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах зохицуулалт” (цуцлах үндэслэл: Захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлээгүй, цаашид тухайн зохицуулалт шаардлагагүй тул мөрдөгдөхгүй); Тус хорооны 2015 оны 7 сарын 29-ний өдрийн 41 тоот тогтоолоор батлагдсан “Тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам”

(цуцлах үндэслэл: Захиргааны хэм хэмжээний актад бүртгэлгүй, ХХЗХ-ны даргын 2023 оны А/53 тоот тушаалаар “Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох дотоод үйл ажиллагааны журам”-ыг баталсан); Тус хорооны 2016 оны 4 сарын 22-ны өдрийн 18 тоот тогтоолоор батлагдсан “Тусгай арга хэмжээний үед радио давтамжийн зохицуулалт хийх, хяналт тавих журам” (цуцлах үндэслэл: Захиргааны хэм хэмжээний актад бүртгэлгүй, АSEM-ийн үед ашиглаж байсан журам, цаашид Зөвшөөрлийн тухай хуулийн энгийн зөвшөөрөл олгох заалтуудаар зохицуулна) зэрэг болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 20 дугаар хуралдаанаар дээр заасан 3 тогтоолыг хүчингүй болгох “Захиргааны хэм хэмжээний актад хийсэн үзлэгийн хүрээнд ЗХХА-д бүртгэлгүй зарим баримт бичгүүдийг хүчингүй болгох тухай” танилцуулга, тогтоол цуцлах тухай эрх зүйн үндэслэл, санал дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцээд, тус хуралдаанаас 3 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

1. Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 210 тоот тогтоолыг баталж, тус хорооны “Зохицуулалтын баримт бичиг батлах тухай” 2014 оны 32 дугаар тогтоолыг цуцлав.
2. Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 211 тоот тогтоолыг баталж, Харилцаа холбооны зохицуулах хорооны “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны 41 дугаар тогтоолыг цуцлав.
3. Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 212 тоот тогтоолыг баталж, тус хорооны “Зохицуулалтын баримт бичиг батлах тухай” 2014 оны 32 дугаар тогтоолыг цуцлав.

ХХЗХ-ны 2024 оны 251 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” (заалт-3.10.8) болон Худалдан авах төлөвлөгөөнд тус тус тусгасны дагуу Радио давтамж хяналт баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх хүрээнд хэрэгжүүлэх “ХХЗХ-ны Радио давтамжийн хяналт баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх хүрээнд оффисын шинэ барилга барих зураг төсөл”-ийн ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг ХХЗХ-ны Даргын 2025 оны А/69 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгээс төслийг гүйцэтгэх этгээдийг сонгон шалгаруулах ХХЗХ/2025010306 нээлтэй тендерийг ТБОНӨХБАҮХТХ-д заасны дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан юм. Тус тендерт шалгарсан Эрчимт төсөл ХХК нь 2025 оны 6 дугаар сараас зураг төслийн ажлыг гүйцэтгээд байна. Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 20 дугаар хуралдаанд ажлын хэсэг, зураг төслийн ажлыг гүйцэтгэгч нар хамтран “ХХЗХ-ны Радио давтамжийн хяналт баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх хүрээнд оффисын шинэ барилга барих зураг төслийн загварын тухай” танилцуулга, мэдээллийг сонсов. Хэлэлцсэн асуудлаар, энэхүү хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдээс гүйцэтгэсэн барилгын зураг загварыг эцэслэхээс өмнө урьдчилсан ТЭЗҮ, холбогдох нэмэлт шаардлагатай зардал, төсөв тооцоо судалгааг боломжийн хэмжээнд (тухайлбал, барилга барих, ашиглалтын үед шаардлагатай дэд бүтэц буюу цэвэр ус, эрчим хүч цахилгаан, дулаан хангамж, шилэн болон уламжлалт барилгын ашиглалтын өртөг, зардлын харьцуулалт, эдийн засгийн үр ашиг г.м)-г дахин судалж, нягтлан боловсруулах талаар гарсан санал зөвлөмж, өгсөн удирдамж чиглэлийг тусган 2025 оны 10 дугаар сард багтаан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхийг хуралдааны тэмдэглэлээр ажлын хэсэгт үүрэг болгохоор тогтов.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 20 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 3 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 3 тогтоолыг батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 213 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Сүү хүнгий ХХК: Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх”) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 214 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Бомбоожоо ЭМБИ ХХК: “Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх”) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 215 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээд, 1 иргэнд олгосон 5 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр сунгаж тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-10-08